

# Амьдрахад таатай газар

# 32

Засгийн газар нь олон нийтийн мөнгийг ашиглан экспортын чиглэлийн үйлдвэрүүдийг цахилгаантай, гудамжны гэрэлтэй, усны болон бохирын шугамтай, хатуу хучилттай замтай, зогсоолтой, утасны үйлчилгээтэй, хамгаалалттай болгосон.

Бас үйлдвэр тэр бүр татвар төлдөггүй. Бид илүү сайн орон сууц, бас ажилчдын үйлчилгээний төлөө зохион байгуулалтад орон шаардлага тавьж байна. Үйлдвэр бидэнд зөвхөн шударга цалингийн өртэй бий, бас илүү сайн орчинг амьдруулах өртэй.



Засгийн газар нь үйлдвэрийг орон нутагт ажиллах зөвшөөрөл өгөх үедээ барилга, зам, цахилгаан болон үйлдвэр үйл ажиллагаа явуулахад хэрэгтэй бусад үйлчилгээг бий болгохоор төлөвлөдөг. Гэвч тэд ажилчдын хэрэгцээг ихэвчлэн тооцдоггүй. Тэдний төлөвлөгөөнд зөвхөн ажилчдын ажлын тоо л ордог, харин тэдний сайн сайхан байдал ордоггүй.

Учир нь экспортын чиглэлийн үйлдвэр нь олон хүн ажилд авч, засгийн газар болон ажил олгогчид нь тэдэнд хангалттай олон нийтийн үйлчилгээ буюу орон сууц, ариун цэвэр, аюулгүй ус, бас тээвэрлэлт зэргийг бий болгосон эсэхийг баталгаажуулах хэрэгтэй. Эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулахын төлөө

тэд явган хүний зам, гудамжны гэрэл, мод тарих, парк болон тоглоомын талбай барих, бас мэдээж ажиллагчдад сургууль, эмнэлэг, соёлын төвүүд барих ёстой.


## Орон сууц

Хятад болон Индонезид ихэнх үйлдвэрийн бүс дэх экспортын чиглэлийн үйлдвэрийн дотуур байр нь зай завсаргүй, маш олон хүнтэй газар ажилчид нь амьдардаг. Бусад газар буюу Мескик болон Кени зэрэг улсад ажилчид өөрсдийн амьдрах орон сууцаа барих эсвэл олох ёстой байдаг бөгөөд ихэвчлэн тухайн бүсэд цахилгаангүй, усгүй, аюулгүй тээврийн хэрэгсэлгүй эсвэл бусад үйлчилгээ нь байдаггүй. Бусад улсад амьдарч байгаа ажилчид ч үүнтэй адил асуудлуудтай нүүр тулгарч, ижил төстэй нөхцөл байдалд байна: тэд ажилтай боловч амьдрах таатай газар тэдэнд байдаггүй.



Бид зургуулаа дотуур байрны өрөөнд амьдарч байна. Энд 100-аас дээш эмэгтэй амьдардаг боловч энд ердөө 4 бие засах газар байдаг ба энд хэзээ ч хангалттай ус байдаггүй. Бид усаа гоод гудамжнаас нийтийн зориулалтын хугаас зөөх ёстой болдог.

Олон үйлдвэрийн ажилчид арай ядан унтах газрынхаа мөнгийг л төлж байна. Гэвч эрүүл байхад танд усанд орох, жорлон хэрэглэх, хангалттай их цэвэр ус уух, хүнсээ аюулгүй хадгалах, бэлдэх, аяга тавгаа хадгалах, сав суулгаа цэвэр байлгах, хувцсаа угаах, хатаах, алжаал тайлах газар хэрэгтэй.



Бид готуур байрандаа илүү сайн хангамжтай байхын төлөө тэмцэж, олон удаа амжилтад хүрч ялалт байгуулсан. Ажил олгогчид ажилчдын цэвэр, аюулгүй амьдрах хэсэгтэй байх эрхийг зөрчиж байгаагаа мэддэг. Бидний олонх нь готуур байранд байдаг ба бид 1000–2000 гарын үсэг маш хурдан цуглуулж, захидал, өргөдөл бичсэн. Бид тэдгээрийг брэндүүд, корпорац бас үйлдвэрийн удирдлага болон үйлдвэрчний эвлэл рүү явуулсан. Бид ялалт байгуулах үедээ илүү хүчирхэгжсэнээ мэдэрсэн.

### Орон сууцны хоршоо байгуулах

Сент Питерийн чөлөөт бүс дэх эмэгтэйчүүдийн бүлэг Ямайкийн экспортын чиглэлийн үйлдвэрийн эмэгтэй ажилчдад гэр болон ажил дээрх туршлагаа ажилчидтай хуваалцах боломж олгож байна. Бид хөдөлмөрийн асуудал, сэтгэл зүйн асуудал болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудлын талаар анги болон зөвлөгөө өгөх ажлын хэсгүүдийг санал болгож байна. Эмэгтэйчүүд бидэнд итгэж эхлэн, бусад ажилчидтай уулзаж бүлэг маань илүү оролцоотой, бас хүчирхэг болсон.

Эмэгтэйчүүдийн хувьд хамгийн их санаа зовоож байгаа асуудлын заримыг шийдэхийн тулд бид цаг хугацаа өнгөрөх тусам арга хэмжээ авч эхэлсэн. Хамгийн том асуудлын нэг нь орон сууцны асуудал байв. Экспортын чиглэлийн үйлдвэр орон сууцаар хангадаггүй ба нийтийн байр нь эмэгтэйчүүдийн сэтгэлд хүрэхгүйн дээр аюулгүй биш газар байв. Бид Канадын Олон улсын хөгжлийн байгууллагаас эмэгтэйчүүдийн орон сууцны хоршоо байгуулах хөрөнгө оруулалт хүссэн юм. Төсөл маш амжилттай хэрэгжсэн ба бид одоо экспортын чиглэлийн үйлдвэрийн бүсийн эргэн тойронд хэд хэдэн орон сууцтай болсон. Манай нийтийн байр нь боломжийн төлбөртэй, цэвэрхэн, бас эмэгтэйчүүдэд аюулгүй юм. Тэнд мөн эмэгтэйчүүд бусад ажилчидтай холбогдох боломжтой газрууд бий. Бид өөрсдийн ангиуд болон ажлын хэсгүүдээ ч мөн тэнд байлгадаг.

## Тээвэр

Олон үйлдвэрийн ажилчдад ажилдаа ирж очих нь сэтгэл зовоосон асуудал байдаг. Автобус ихэвчлэн өглөө эрт, шөнө орой тардаг ажилчдад үйлчлэхээр явдаггүй. Шөнө оройтож эсвэл өглөө эрт үйлдвэрүүдийн ойролцоо явах нь ялангуяа эмэгтэй ажилчдад аюултай байдаг. Олон эмэгтэй ажилчин ажлаа таран, үйлдвэрийг орхисны дараа гэртээ харих аюулгүй тээвэр байхгүйгээс хүчиндүүлж эсвэл амь насаа алдаж байна. Олон ажилчин урт ажлын өдөртэй ч дахин олон цагийг ажилдаа ирж очиход зарцуулж байна.

Ажил гэрийн хооронд аюулгүй тээвэртэй байх нь ажилчдыг халдлага, дээрэм, хүчирхийллээс хамгаалах нэг арга юм. Тээвэрлэлтийг боломжтой байлгаснаар ажилчдын стресс болон ядаргааг багасгаж, тэдэнд илүү олон цаг амрах, дэлгүүр явах, хүнсээ бэлдэх, хувийн хэрэгцээндээ анхаарах цаг гаргахад нь тусална.

Хэд хэдэн өөр бүлгүүдийн туршиж үзсэн дараах аргууд байна:

- Ажилчдыг үйлдвэрээс, ялангуяа нар мандахаас өмнө болон нар жаргасны дараа **үнэгүй, хөнгөлөлттэй эсвэл хямд үнэтэй тээврийн хэрэгслээр хангахыг ойлгуулах;**
- Ажилчдыг үйлдвэрийн бүсэд ирэх болон явахад нь үйлчлэх автобусны үйлчилгээ эхлэхийг **орон нутгийн засаг захиргаанд ятган ойлгуулах;**
- **Орон нутгийн автобус тээврийн үйлчилгээг** илүү олон чиглэлд буюу ажилчдад хэрэгтэй үед нь тэднийг цаг алдалгүй ажлаас нь аюулгүй авдаг болгож өргөжүүлэх.

Автобусны жолооч нарт ойлгуулж, хэрвээ олон ажилчин үйлчлүүлдэг бол тэдэнд илүү олон чиглэлд явж, тодорхой цагаар үйлчлэх бизнесийн санал тавих нь зүйтэй юм.



Илүү сайн тээвэрлэлтийн төлөө зохион байгуулагдаж байхдаа бүлгүүд нь ажилчид ажилдаа ямар нэг аюулгүй явах, ирэх кампанит ажлыг зохион байгуулдаг. Та болон таны хамтран ажиллагчид хаана амьдардаг талаар зураглал гаргаж тэдэнд алхах, дугуй унах эсвэл нийтийн тээврийн хэрэгслээр хамтдаа зорчих нөхөрлөлийн систем бий болгоход нь тусал.



### Илүү аюулгүй гудамжны төлөөх тэмцэл

Шри Ланкийн Катунаяакэгийн худалдааны чөлөөт бүсэд орон нутгаас болон тухайн бүсийн гаднах нийтийн байрнаас ирсэн мянга мянган залуу эмэгтэй ажилчид бий. Үйлдвэрчний эвлэлийн зохион байгуулагчид нийтийн байрны ажилчдын санаа зовж байгаа асуудлын талаар судалгаа хийсэн байна. Эмэгтэйчүүд үйлдвэр рүү очих болон үйлдвэрээс шөнө орой явах үед дээрэм болон хүчингийн хэрэг олноор үйлдэгддэг тул тэдэнд аюултай санагддаг талаар олж мэдэв.

Зохион байгуулагчид эмэгтэйчүүдийг цуглуулан хамтдаа тэдний асуудлын талаар ярилцаж, шийдлийг олох, тэргүүлэх чиглэлийг тогтоох, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэв. Ажилчид кампанит ажлуудыг зохион байгуулж, хэд хэдэн чухал өөрчлөлтөд хүрч ялалт байгуулав.

(үргэлжлэл)

**Цагдаагийн шинэчлэл:** Эрэгтэй цагдаа нар эмэгтэйчүүдийн санаа зовж байгаа асуудалд хойрго ханддаг, тэдэнд халдсан тохиолдол бүрийг мөрдөн шалгах хүсэлгүй байдаг байв. Эмэгтэйчүүд эрэгтэй цагдаа нар зөвхөн тэднийг үл хүндэтгэсэн байдалтай байна гэдгээс болж халдлагын талаар мэдээлдэггүй байв. Ажилчид цагдаагийн хэлтэст эмэгтэйчүүдийн асуудлыг хариуцсан албатай болгох хэрэгтэйг ойлгуулж, 24 цагийн турш эмэгтэй ажилтан тэнд суухаар болгов. Одоо ч гэсэн цагдаатай асуудалтай хэвээр байгаа ч нөхцөл байдал нь хавьгүй дээрдсэн байна.

**Гудамжны гэрэл:** Гудамжны гэрэл нь үйлдвэрийн бүс, нийтийн байрны эргэн тойронд суурилуулсан ч бүх газарт жигд ажилладаггүй. Зарим нь элэгдэж эвдэрсэн эсвэл гудамжийг харанхуй байлгах хүсэлтэй хүмүүс гэрлийг албаар эвдсэн байдаг ажээ. Засвар хийх нь тун ховор байдаг. Ажилчид эвдэрсэн гэрлийг засах, асуудал гарах бүрт засварлуулахаар засаг захиргаатай тохиролцсон юм.

**Нийтийн тээврийн үйлчилгээ:** Ажилчид нийтийн тээврийн автобусыг нийтийн байртай хэсэг болон үйлдвэрлэлийн бүсийн хооронд явуулж эхлэхийг засгийн газраас шаардсан юм. Автобусны чиглэл нь илүү хүрэлцээтэй болж эхэлсэн ба дараа нь үйлдвэрчний эвлэл үйлдвэрийн эздээр 2 автобус тухайн үйлчилгээнд зориулж нэмж авхуулж чадсан юм. Зөвхөн эмэгтэйчүүд илүү аюулгүй байдлыг мэдэрсэн. Бас тэд өдөр бүр 3 км алхдаггүй болсон байна.

Эдгээр өөрчлөлт нь хүчирхийлэл, хүчингийн хэрэг гаралтыг багасгаж, эмэгтэйчүүдэд орон нутагтаа өөрчлөлт хийхийн тулд зохион байгуулалтад орох хэрэгтэй байдаг талаар ихийг сурахад тусалсан юм. Одоо ажилчид, ялангуяа шөнө үйлдвэрээс гарах үедээ бие биедээ илүү их санаа тавьдаг болсон билээ.

